# ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХЭЛТСИЙН САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ГАНБАТЫН ЭНХТУЛГЫН
# 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх нэгдсэн бодлого төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах”** | | | | | | | | |
| 1. | 1. | **Арга хэмжээ 1.1.** Цахим шилжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай салбар хоорондын зохицуулалтыг хангах чиглэлээр шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 9 | 2 | Цахим шилжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай салбар хоорондын зохицуулалтыг хангах чиглэлээр шийдвэрийн төслүүдийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Үүнд:<br>1. Эрүүл мэндийн тухай хуулийн 8.4 дэх хэсэгт заасан журмын төслийг Эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулж, 1а/821 (ЭМС) бичгээр хүргүүлж, улмаар 100 дугаар тогтоол батлагдсан.<br>2. Ерөнхий сайдын 2023 оны 206 дугаар захирамжийн хүрээнд эрүүл мэндийн цахим шилжилтийн талаар танилцуулга, материалыг бэлтгэн 01/611, 01/04 тоот бичгээр 2 удаа хүргүүлж, улмаар 12, 24 дүгээр хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын 2024 оны “Захирамжид өөрчлөлт оруулах тухай” 46 дугаар захирамж батлагдсан.<br>3. Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд шил ажиллагааны хэрэгжилтийн талаар танилцуулга, материалыг бэлтгэн, 01/241 тоот бичгээр хүргүүлж, улмаар 15 дугаар хуралдааны тэмдэглэл батлагдсан.<br>4. Засгийн газрын 2023 оны 46 дугаар тэмдэглэлийн хүрээнд цахим шилжилтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдааг хангах талаар тогтоолын төсөл, материалыг бэлтгэн, 01/1016 тоот бичгээр хүргүүлж, улмаар 215 дугаар тогтоол батлагдсан. | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5. Иргэд Үндэсний баялгийн сангаас эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн санхүүжилт авах хүсэлтээ “E-Mongolia.mn” системээр дамжуулан өгөх боломжийг бүрдүүлсэн талаар танилцуулгыг бэлтгэж, цахимаар хүргүүлж, улмаар 19 дүгээр хуралдааны тэмдэглэл батлагдсан.<br>6. Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар өгсөн үүргийн дагуу төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудасны талаар танилцуулга, материалыг бэлтгэн, 01/208 тоот бичгээр хүргүүлж, улмаар 31 дүгээр хуралдааны тэмдэглэл батлагдсан.<br>7. Засгийн газрын 2024 оны хуралдааны 13, 35 дугаар тэмдэглэлийн хүрээнд Иргэд, олон нийттэй харилцах төв /11-11/-д 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Сайд ажилласан талаар танилцуулга, тэмдэглэлийн төслийг боловсруулж, 01/984 тоот бичгээр хүргүүлж, улмаар улмаар 41 дүгээр хуралдааны тэмдэглэл батлагдсан. | | |
| 2. | 2. | **Арга хэмжээ 1.2.**<br>Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээг хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай санал, хүсэлт, чиглэлийг холбогдох байгууллагад хүргүүлэх замаар хэрэгжилтийг хангуулна. | Хүргүүлсэн албан бичгийн тоо | - | 4 | Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээг хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай 81 төрлийн санал, хүсэлт, чиглэл, мэдээллийг бэлтгэн, албан бичгээр давхардсан тоогоор 439 байгууллагад хүргүүлсэн. Үүнээс Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт 20, Үндэсний дата төв УТҮГ-т 17, И-Монгол академи УТҮГ-т 18 тус тус хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.<br>Мөн Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай” 213 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулахад шаардлагатай эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн 161 мэргэжилтнүүдийн судалгааг 63 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, агентлагаас авч нэгтгэн, 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2. "Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний бодлого, журам, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах"** | | | | | | | | |
| 3. | 1. | **Арга хэмжээ 2.1.** Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт өгнө. | Хүргүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн тоо | 3 | 2 | Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд дараах зөвлөмж, дүгнэлтийг боловсруулж, мэдээлэл хариуцагч байгууллагад хүргүүлсэн. Үүнд:<br>1. "Дата удирдлагын систем болон соёлын салбарын статистикийн систем" хөгжүүлэх ажлын даалгаварт 2024 оны 6 дугаар сарын 04-ний өдөр цахим шуудан (altantuya@moc.gov.mn, info@moc.gov.mn)-аар Соёлын яаманд;<br>2. "Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцооны систем (LIMS)"-ийн нэмэлт хөгжүүлэлтийн ажлын даалгаварт 2024 оны 7 дугаар сарын 18-ны өдөр цахим шуудан (labinfo@nrl.gov.mn ariuntungalag@nrl.gov.mn)-аар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид;<br>3. "Зам, тээврийн нэгдсэн системийн бүрдэл RFID уншигчийн мэдээлэл цуглуулан боловсруулах систем болон системүүдийн өгөгдөл замчлан дамжуулах API Gateway хөгжүүлэлт"-ийн ажлын даалгаварт 2024 оны 8 дугаар сарын 01-ны өдөр цахим шуудан (info@mrt.gov.mn)-аар Зам, тээврийн хөгжлийн яаманд;<br>4. Жендэрийн үндэсний шинжээч, мэргэжилтэн, сургагч багш нар харилцан үйл ажиллагаагаа уялдуулах, хяналт үнэлгээ хийх онлайн платформд 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 01/487 тоот албан бичгээр Жендэрийн үндэсний хороонд;<br>5. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргасан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тогтоолууд дахь цахим шилжилтийн үйл ажиллагаанд холбогдох зөвлөмжийг 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр цахим шуудан (emduzalba@gmail.com)-аар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд;<br>6. Гадаадын иргэнд олгож байгаа оршин суух үнэмлэх хэвлэлтийг киоск машинаас өөрийн биеэр хэвлэн авах | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | программ хангамжид 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдөр Гадаадын иргэн, харьяатын газарт;<br>7. "Тээврийн хэрэгслийн нэгдсэн удирдлагын систем" хөгжүүлэх ажлын даалгаварт 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдөр Зам, тээврийн яаманд. | | |
| **Зорилт 3. "Нийгэм, эдийн засгийн салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэглээг бий болгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах"** | | | | | | | | |
| 4. | 1. | **Арга хэмжээ 3.1. Ямны гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 31.** Эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ. | Мэдээлэл солилцох сервисийн тоо | 33 | 40 (100%) | - Ерөнхий сайдын 2023 оны 206 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллаж, 8 удаагийн хурлыг зохион байгуулсан бөгөөд үр дүнг Засгийн газрын 2024.03.26, 2024.07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг хангасан.<br>- Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцооны ерөнхий схем /HealthESB/, сервисийн гарын авлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, үндсэн системд **24 шинэ API сервисийг** нэвтрүүлсэн. Хөгжүүлэлтийн 6 удаагийн туршилтыг хийж, 2024 оны 4 дүгээр сарын 03,17-ны өдөр 4 эмнэлэг, ЭМДЕГ, ЧДХХҮГ дээр очиж шалгасан.<br>- Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), Хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн.<br>- Эмнэлгийн систем хөгжүүлэгч 8 компанитай гэрээ байгуулах VPN, API-г тохируулах бэлтгэл ажлыг хангаж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2024.12.01-ний өдөр хүртэл чөлөөлүүлсэн.<br>- Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 зогсуур, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг Үндэсний дата төвөөс үзүүлж байгаа судалгааг гаргасан.<br>- Эрүүл мэндийн 9 үйлчилгээг eMongolia системд нэвтрүүлэн бүрэн ашиглалтад оруулж, иргэд, олон нийтэд хүргэх мэдээллийн контентыг боловсруулж, түгээсэн.<br>- "Эмийн жорын маягт, жор бичилт, жороор олголтод тавих шаардлага" MNS 5376:2016-ыг шинэчлэх | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төсөлд цахим жор бичилттэй холбоотой тусгах саналыг боловсруулж, 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт цахимаар хүргүүлсэн.<br>- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргасан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тогтоолууд дахь цахим шилжилтийн үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлаар харилцан мэдээлэл солилцох, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт хамран ажиллаж, 2024.09.12, 13, 17, 18, 19-ны өдрүүдэд Номун эмнэлэг, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв, 10 хорооны "Ариун чанар" ӨЭМТ, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв, 16-р хорооны "Тэгш-Өлзий" ӨЭМТ нийт 6 эмнэлэг дээр очиж ажиллан, эмч, ажилтнуудын санал хүсэлтийг хүлээн авч, цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулж Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлсэн. | | |
| 2. | **Дэд арга хэмжээ 3.1.1.** Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 206 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг болон эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр оролцогч талуудыг хамарсан вакум | Хэлэлцүүлгийн тоо | - | 1 (25%) | Нийт 10 удаагийн вакум уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Үүнд:<br>1. 2024.01.04-ний өдөр эрүүл мэндийн цахим шилжилтийн чиглэлээр эмнэлгийн мэдээллийн технологийн инженер болон эмнэлгийн систем хөгжүүлэгч компанийн төлөөлөл нийт 53 байгууллагын 60 ажилтны дунд<br>2. 2024.01.05-06-ны өдрүүдэд ажлын хэсгийн төлөвлөгөөний вакум хэлэлцүүлгийг 17 байгууллагын 35 албан хаагчдад<br>3. 2024.04.08,09-ний өдрүүдэд "Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд" үндэсний зөвлөлдөх уулзалтыг 150 байгууллагын 380 ажилтанд /digitalhealth.gov.mn/<br>4. 2024.04.01-12-ны өдрүүдэд "Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээ" судалгааны уулзалтыг Азийн цахим эрүүл мэндийн холбоо /AeHIN/ 3, | 2024.01.01-2024.12.10 | (25%) Дэд арга хэмжээ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэлэлцүүлэг зохион байгуулна. | | | | ЦХХХЯ 1, ЭМЯ 1, ЭМХТ 1, ЭМДЕГ 2, Эмнэлэг 21 нийт 8 байгууллагын 29 албан хаагчдад<br>5. 2024.04.12-ны өдөр анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын программ хангамжид тулгамдсан асуудлын чиглэлээр ЦХХХЯ 2, ЭМЯ 1, ЭМХТ 2, ГТСМТТ 1, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо 1 нийт 5 байгууллагын 7 удирдлагын хэмжээнд<br>6. 2024.04.16-ны өдөр өрх, сумын эмнэлгийн цахим шилжилтийн чиглэлээр анхан шатлалын эрүүл мэндийн 102 байгууллагын 200 төлөөлөлд<br>7. 2024.04.19,22-ний өдөр eMongolia системд “Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч карт” болон “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг нэвтрүүлэх хүрээнд ХНХЯ, ЦХХХЯ, ГТСМТТ, ЭМЯ, Мэргэжлийн салбар зөвлөлүүд, систем хөгжүүлэгч 7 компани нийт 12 байгууллагын 30 гаруй ажилтны дунд<br>8. 2024.04.30, 05.01-ний өдрүүдэд системийн туршилтыг Өргөө амаржих газар, СБД-ийн ӨЭМТ, ЭМХТ, ГТСМТТ, ЭМДЕГ, И-Монгол акдеми, эмнэлгийн систем хөгжүүлэгч 7 компани нийт 13 байгууллагын 15 ажилтны дунд<br>9. 2024.05.04-24-ний өдрүүдэд Эрүүл мэндийн яамтай хамтран 21 аймаг, нийслэлд бүсчилсэн хэлбэрээр сургалт зохион байгуулж, салбарын нийт ажилтнуудад<br>10. 2024.12.06-ны өдөр эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг мэдээллийн технологийн 16 аж ахуйн нэгжүүдийн 26 албан хаагчдын дунд<br>11. 2024.10.22-ны өдөр Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд удирдлагуудыг нэгдсэн мэдээллээр ханган, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор “Өөрчлөлтийн менежмент ба өглөөний уулзалт” /convergence workshop/-ыг тус тус зохион байгуулсан. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3. | | Хамрагдсан байгууллагын тоо | - | 10 (5%) | Дээрх вакум уулзалт хэлэлцүүлэгт нийт 391 байгууллагын 782 ажилтан, холбогдох удирдлагыг хамруулсан. | 2024.01.01-2024.06.30 | (5%) Дэд арга хэмжээ |
| | 4. | **Дэд арга хэмжээ 3.1.2.** Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр оролцогч талуудын оролцоог хангасан хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, батлуулна. | Төлөвлөгөө батлагдсан эсэх<br><br>(тийм-1, үгүй-0) | - | 1 (30%) | Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж, 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлуулж, оролцогч талуудад 02/170 тоот бичгээр хүргүүлэн, хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулсан. | 2024.01.01-2024.02.28 | (30%) Дэд арга хэмжээ |
| | 5. | **Дэд арга хэмжээ 3.1.3.** Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн чиглэлээр батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх “Дэд ажлын хэсэг”-ийг байгуулах тушаалын төсөл боловсруулж, батлуулах замаар хэрэгжилтийг хангуулна. | Дэд ажлын хэсгийн тушаал батлагдсан эсэх<br><br>(тийм-1, үгүй-0) | - | 1 (40%) | Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 206 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Дэд ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар батлуулж, 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 03/76 тоот бичгээр ажлын хэсгийн гишүүдэд (21 байгууллагад) хүргүүлсэн.<br>Тус дэд ажлын хэсгийн нарийн бичгээр томилогдон ажиллаж, 3 багийн хүрээнд төлөвлөгөөний хэрэгжилтийг мэргэжил арга зүйгээр хангаж, биелэлтийг хариуцсан ажилласан. Үүнд:<br>1. Баг I: "Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээ"-ний судалгааг нийт 325 байгууллагаас авч, үр дүнг 4 дүгээр сарын 08, 09-ний өдрүүдэд эрүүл мэндийн салбарын 380 ажилтан, холбогдох удирдлагад, 6 дугаар сарын 12-ны ажлын хэсэгт тус тус танилцуулсан. Эцсийн тайланг хүлээн авч, | 2024.01.01-2024.12.10 | (40%) Дэд арга хэмжээ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | редакцын хяналтыг хийж, олон нийтэд ил тод байршуулсан. Үнэлгээгээр эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн өнөөгийн нөхцөл байдал нийт 5 оноо авахаас 2.9 байна.<br>2. Баг II: 2024.08.30-ны өдрийн байдлаар 346 эмнэлэг холбогдсон. И-Монгол системд “Эмийн жор”-ыг 2024.03.27-нд, 70 төрлийн 120 эмийг AR технологиор баяжуулж 2024.04.18-нд, оношилгоо, шинжилгээний хариу, дүгнэлт, жирэмсний хяналтын хөтөч карт, хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ, амбулаторийн картыг 2024.05.07-нд, эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг 2024.05.31-нд хэрэглээнд нэвтрүүлсэн ба 17,437,952 мэдэгдлийг хүргэж, 729,055 хандалтыг авсан. 70 төрлийн 120 эмийг AR технологиор баяжуулж 2024.04.18-ны өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн. Хэрэглэгчид эмийн хэрэглэх заавар, хориглох заалт, гаж нөлөө гэх мэт тухайн эмийн хэрэглээтэй холбоотой бүх мэдээллийг эмийн хайрцаг дээрээсээ ойлгомжтой аудио тайлбар, дохионы хэл, текст хэлбэрээр авах боломжтой болсон.<br>3. Баг III: Эрүүл мэндийн тухай хуулийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмын төслийг боловсруулж, Засгийн газрын 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХХХС-ын А/138, А/37 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан.<br><br>Цаашид хамтран ажиллах талаарх 2024 оны 8 дугаар сарын 06 өдрийн 01/74 тоот албан бичгийг Эрүүл мэндийн сайдад хүргүүлсэн. | | |
| 5. | 6. | **Арга хэмжээ 3.2. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний № 32.** Хөдөлмөр, нийгмийн | Арга хэмжээний тоо | - | 1 | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэд эрүүл мэндийн лавлагаа, тодорхойлолтыг цаасаар гаргуулан, харьяалах анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага дээр очиж Эрүүл мэндийн даатгалын “health.gov.mn” системд бүртгүүлдэг ба анх лавлагаа, тодорхойлолт олгож буй эмнэлгээс шууд бүртгэх боломжгүй, өрх, сумын эмнэлгийн эмчийн ачааллыг нэмэгдүүлж байгаа талаар 2024 оны 4 дүгээр сарын 17- | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамгааллын салбарын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлнэ. | | | | ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран дүүргийн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар дээр очиж судалсан. Эрүүл мэндийн даатгалын "health.gov.mn" систем болон Халамжийн нэгдсэн "ehalamj.mn" систем хоорондоо шууд холбогдсон нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9 дэх "Мэдээлэл хариуцагч хоорондоо болон мэдээлэл хариуцагчаас хүн, хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр мэдээлэл солилцохдоо үндсэн системийг ашиглана." гэж заасныг зөрчиж байсныг илрүүлсэн. Улмаар холбогдох чиглэлийг 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 03/945 тоот бичгээр И-Монгол Академи УТҮГ-т хүргүүлж, тус 4 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг анх бичиж буй эмнэлгээс шууд үндсэн систем "ХУР"-д нийлүүлэх API сервис (WS300167_GetChildrenBirthInfo, WS300166_GetEcareByRegnum)-ийн хөгжүүлэлтийг хийлгэж, Үндэсний дата төв, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн.<br>Түүнчлэн хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт шаардлагатай мэдээллийг Засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу "Эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны систем"-ээр дамжуулан үндсэн систем (ХУР)-д нийлүүлэх тухай 2024 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 03/1133 тоот бичгийг Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн.<br>Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/101 дүгээр тушаалын дагуу нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлэх салбар дундын ажлын хэсэгт ажиллаж, хариуцсан чиг үүргийн дагуу мэдээллийг боловсруулан ажиллаж байна. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4. “Нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах”** | | | | | | | | |
| 6. | 1. | **Арга хэмжээ 4.2. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний №44.** Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарыг нэвтрүүлнэ. | Нэвтрүүлсэн хувилбар | 1.0 хувилбар | 2.0 хувилбар (100%) | - Нээлттэй мэдээллийн “shilen.gov.mn” системийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж, 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр 2.0 хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлсэн ба 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Тус 2.0 хувилбарт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд хиймэл оюуны (GPT) технологийг сургаж, мэдээлэл хариуцагч хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллээ байршуулах, үнэн зөвийг хариуцах, өөрийн системийг шууд холбох боломжийг бүрдүүлсэн. Мөн 2023 оны бүх мэдээллийг шинэ хувилбарт хөрвүүлэн байршуулсан.<br>- 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар “shilen.gov.mn” 2.0 системд мэдээлэл хариуцагч 1413 байгууллагын 1,635 албан хаагчийг бүртгэж, 1021 албан хаагчдад сургалт хийсэн.<br>- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан мэдээлэл хариуцагч байгууллагыг бүрэн хамруулах зорилгоор 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 03/1279 тоот бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн.<br>- Мөн хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг тус системд байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хамтран ажиллах талаар талаар 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/924 тоот албан бичгийг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг даргад болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. | 2024.01.01 - 2024.12.10 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2. | **Дэд арга хэмжээ 4.1.1.** Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарыг Үндэсний дата төвд байршуулна. | Үндэсний дата төвд байршуулсан эсэх (тийм-1, үгүй-0) | 1 | 1 (40%) | Үндэсний дата төвийн "mcloud" серверт нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn 2.0" системийн backend, frontend, Portalsite зэрэг нийт 25 cloud серверийг тохируулан 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдөр байршуулсан.<br>Мөн тус системийг үндсэн систем "ХУР"-ээс байгууллага, иргэний мэдээлэл дуудах, хэрэглэгчийн эрх үүсэхэд автоматаар мэйл хүргүүлэх, байгууллагын админууд өөрийн байгууллагын хэрэглэгчдийг үүсгэх зэрэг нэмэлт хөгжүүлэлтийг гүйцэтгэгч "Аствишн" ХХК-аар хийлгэсэн. | 2024.01.01 - 2024.06.30 | (40%) Дэд арга хэмжээ |
| | 3. | **Дэд арга хэмжээ 4.1.2.** Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарын гарын авлага боловсруулна. | Боловсруулсан гарын авлагын тоо | - | 2 (20%) | Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 8 төрлийн гарын авлагыг боловсруулан, цахим хэлбэрээр байршуулж, 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 01/1142 тоот албан бичгээр Засгийн гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. | 2024.02.01 - 2024.06.30 | (20%) Дэд арга хэмжээ |
| | 4. | **Дэд арга хэмжээ 4.1.3.** Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарыг ашиглах сургалтыг зохион байгуулна. | Хамрагдсан байгууллагын тоо | - | 40 (40%) | Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" 2.0 системд хандах эрх олгох, сургалтад хамруулах тухай 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 01/817 тоот албан бичгийг Засгийн газрын гишүүд, Аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт, шил ажиллагааны хүрээнд хамтран ажилласан 123 байгууллагын 257 албан хаагчдад цахим шуудангаар хүргүүлсэн.<br>Сургалтыг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран зохион байгуулж, мэдээлэл хариуцагч 1021 албан хаагчийг хамруулсан. Мөн системд цахим сургалтын материалаар хангаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж байна. | 2024.03.01 - 2024.06.30 | (40%) Дэд арга хэмжээ |

| Зорилт 5. “Төрийн байгууллагуудын мэдээллийн систем, нээлттэй өгөгдөл, мэдээллийг уялдуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах” | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | 1. | **Арга хэмжээ 5.1.** Мэдээллийн системийн бүртгэл, зөвлөмжийн нэгдсэн бүртгэлийн систем нэвтрүүлнэ. | Нэвтрүүлсэн системийн тоо | - | 1 (100%) | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.12 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт тус яамнаас гаргуулах үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор “Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем”-ийг 2024 оны 2 дугаар сарын 20-ны өдөр ашиглалтад бүрэн оруулсан.<br>Системийг хөгжүүлэгч “Энгүй шийдэл” ХХК-тай байгуулсан ЦХХХЯ/202310069 гэрээний баталгаат хугацаанд багтаан нэмэлт сайжруулалтын саналыг өгч гүйцэтгүүлэн, 2024 оны 4 дүгээр сарын 05,12,19-ний өдөр буюу нийт 3 удаагийн техникийн туршилтыг амжилттай зохион байгуулсан.<br>Тус системийг үйл ажиллагаандаа ашиглах, сургалтад хамрагдах талаар 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/1256 тоот бичгийг аймаг, нийслэлийн Засаг даргад, мөн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/923 тоот бичгийг Засгийн газрын гишүүд болон нийт мэдээлэл хариуцагч 48 байгууллагад тус тус хүргүүлсэн. | 2024.01.01 - 2024.12.10 | 100% |
| | 2. | **Дэд арга хэмжээ 5.1.1.** Мэдээллийн системийн бүртгэл, зөвлөмжийн нэгдсэн бүртгэлийн системийг Үндэсний дата төвийн клауд (MCloud) | Mcloud-д байршуулсан эсэх (тийм-1, үгүй-0) | - | 1 (40%) | “Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем”-ийг Үндэсний дата төвийн клауд (MCloud) серверт 2024 оны 2 дугаар сард байршуулсан. Үүнд:<br>- Машины төрөл: Cloud 4<br>- Санах ой (RAM): 8gb<br>- Үйлдлийн систем: Ubuntu-22.04 LTS<br>- Core CPU: 4 vCPU<br>- Диск: 50gb<br>- Домайн: esr.gov.mn | 2024.01.01 - 2024.03.31 | (40%) Дэд арга хэмжээ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | серверт байршуулна. | | | | | | |
| | 3. | **Дэд арга хэмжээ 5.1.2.** Мэдээллийн системийн бүртгэл, зөвлөмжийн нэгдсэн бүртгэлийн системийн гарын авлага боловсруулна. | Боловсруулсан гарын авлагын тоо | - | 1 (20%) | “Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем /isr.gov.mn/”-ийн администраторын тохиргооны, дүгнэлт, зөвлөмж гаргах ажлын хэсгийн болон мэдээлэл хариуцагч байгууллагын ажиллах нийт 3 төрлийн гарын авлагыг боловсруулж, системд цахим хэлбэрээр байршуулсан. | 2024.03.01 - 2024.05.31 | (20%) Дэд арга хэмжээ |
| | 4. | **Дэд арга хэмжээ 5.1.3.** Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад мэдээллийн системийн бүртгэл, зөвлөмжийн нэгдсэн бүртгэлийн системийг ашиглах сургалтыг зохион байгуулна. | Хамрагдсан байгууллагын тоо | - | 38 (40%) | “Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем” /isr.gov.mn/-ийг ашиглалтад оруулсантай холбогдуулан цахим сургалтыг 2024 оны 6 дугаар сард 2 удаа 21 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн захиргааны төв 16 байгууллага буюу мэдээлэл хариуцагч 38 байгууллагын хэмжээнд зохион байгуулсан. | 2024.03.01 - 2024.12.10 | (40%) Дэд арга хэмжээ |
| 8. | 5. | **Арга хэмжээ 5.2.** Соёлын салбарын цахим | Нэвтрүүлсэн системийн тоо | - | 1 | Соёлын салбарын цахим шилжилтийн хүрээнд “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем”-ийг Соёлын яамтай хамтран 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн. (ncch.cis.mn) | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 6. | шилжилтийн хүрээнд “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем”-ийг нэвтрүүлнэ. | Хэрэглэгч байгууллагын тоо | - | 3 | Соёлын салбарын цахим шилжилтийн хүрээнд “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем”-ийг эхлээд Говьсүмбэр, Дархан-Уул, Архангай аймагт нэвтрүүлж, жилийн эцсийн байдлаар 21 аймаг нэвтрүүлсэн. /21 аймаг, нийслэлийн хэмжээнд 9,590 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, 7,100 түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл (дэс), 14,123 түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, 1,554 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар, 15,274 түүх, соёлын үл хөдлөх дурсгал, 5 баримтат өв бүргэгдээд байна./ | 2024.01.01-2024.12.10 | 100% |
| **ХОЁР. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| 9. | 1. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнана. | Батлагдсан төлөвлөгөөний тоо | 2 | 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлуулсан. | 2024.01.01-2024.12.10 | 100% |
| | | | Тайлангийн тоо | 2 | 2 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн 2024 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн тайланг боловсруулж, заасан хугацаанд Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.10 | 100% |
| 10. | 2. | Хариуцсан чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон | Хариуцсан чиглэлээр холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалта | 26 (Долоо хоногийн тайлан) 10 (Сарын тайлан) | Хэрэгжилтээр | Гүйцэтгэсэн ажлын тайланг 7 хоног бүр, хэлтсийн болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг сар бүр нэгтгэн боловсруулж тайлан хариуцсан албан хаагчдад хүргүүлэн ажилласан. | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | нд хүргүүлсэн байна | | | | | |
| 11. | 3. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлана. | Архивд хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо | 1 | Хэрэгжилтээр | Боловсруулсан албан бичгийн төслийг бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэнд, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, тушаалын төслийг хуулийн мэргэжилтэнд, тайлан, түүний холбогдох баримтыг тайлан хариуцсан мэргэжилтэнд тус тус тухай бүр хүлээлгэн өгч ажилласан. | 2024.01.01-2024.12.10 | 100% |
| 12. | 4. | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо | 5 (2023 оны гүйцэтгэлийн тайлан) | Хэрэгжилтээр | "Шил" ажиллагааны нээлттэй мэдээллийн (shilen.gov.mn) систем дэх "Хөдөө аж ахуйн корпорац"-ийн эргэн төлөлтийн мэдээлэлд хасалт хийлгэх талаар иргэн Э.Баярцогт 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдөр тус яаман дээр өөрийн биеэр ирж гомдол гаргасныг судлан үзэж, газар дээр нь шийдвэрлэсэн. | 2024.01.01-2024.12.10 | 100% |
| 13. | 5. | Авлигын эсрэг хууль, Нийтийн | ХАСХОМ бөглөх | 5 | 1 | Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг 2024 оны 2 дугаар | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | болон хуулийн хэрэгжилтийг хангаж, ажилласан баримтын тоо | (2023 оны гүйцэтгэлийн тайлан) | | сарын 04-ний өдөр буюу хуульд заасан хугацаанд багтаан мэдүүлсэн.<br><br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон программ хангамжийн API сервис хөгжүүлэгч Э.Цэнгүүн, С.Баттулга нартай байгуулсан г/25е, г/26 тоот гэрээг боловсруулахад аливаа ашиг сонирхлын зөрчилгүйгээ 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр илэрхийлж, мэдэгдэл гаргаж Хуулийн хэлтэст өгсөн. | | |
| 14. | 6. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | Өгсөн үүрэг даалгаврын тоо | 17 (2023 оны гүйцэтгэлийн тайлан) | Хэрэгжилтээр | - Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/91, А/92 дугаар тушаал, холбогдох ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Тус тушаалын дагуу 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн г/25, г/26 дугаартай гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллаж, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Мөн гэрээний материалуудыг Хуулийн хэлтэс, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс хүлээлгэж өгсөн.<br>- Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/47 дугаар тушаалаар байгуулагдсан "Цахим соёл" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсэгт ажиллаж, "Номын сангийн удирдлагын программ–Коха систем", хэрэглэгчийн веб сайт, мобайл апп, хайлтын систем бүхий "Номын сангийн нэгдсэн систем"-ийг хөгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавин, 2024.05.27-ны өдөр хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болгосон.<br>- Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/18, А/25 дугаар тушаалыг нэгтгэн, нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журмын төслийг хамтран боловсруулсан. | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах зорилт, арга хэмжээний саналыг боловсруулахад хамтран ажилласан.<br>- Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/49 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд хариуцсан чиг үүргийн хүрээнд салбарын стратеги, төлөвлөгөөний төслийг боловсруулсан.<br>- Мэдээлэл, харилцаа холбооны технологи, цахим засаглалын хүрээнд олон улсын түвшинд хийгддэг 50 гаруй индексийг судлан, түүнээс "NETWORK READNESS INDEX"-д Монгол Улсын нөхцөл байдал хэрхэн үнэлэгдсэн талаарх танилцуулга, цаашид авах арга хэмжээний саналыг бэлтгэн 2024 оны 8 дугаар сарын 23-ны өдөр удирдлагад өгч, хэлтсийн албан хаагч нарт танилцуулсан.<br>- 2024.09.02-06-ны хооронд зохион байгуулагдсан "Open Data Hackathon" үйл ажиллагаанд менториор оролцож, "Эрүүл мэндийн салбарын цахим шилжилт" сэдэвт илтгэлийг танилцуулан, оролцогч байгууллагуудад мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан.<br>- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны ""И-Монгол академи" УТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын нэр, орон тоог шинэчлэн батлах тухай" А/31 дүгээр тушаалыг батлуулсан.<br>- "Өгөгдлийн интеграци ХУР&ДАН шийдэл" сэдэвт уулзалтын бэлтгэл ажлыг хангаж, мэдээллийг 2024.11.19-ний өдрийн 03/920 тоот бичгийг мэдээлэл хариуцагч 55 байгууллагад хүргүүлж, 2024.11.22-ны өдөр Үндэсний дата төв УТҮГ, И-Монгол академи УТҮГ-тай хамтран зохион байгуулсан.<br>- Хариуцсан чиг үүргийн хүрээнд цаг үеийн шинжтэй судалгаа, ажлын даалгавар, тайланг боловсруулж, нийт 115 албан бичгийг судлан үзэж, шийдвэрлэсэн. | | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Эрхэлсэн ажлын чиглэлээр олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох | Олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцсон тоо | 2 | 1 | 1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дугаар сарын 26-ны өдрийн А/52 дугаар тушаалаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо 2024 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 11 дүгээр сарын 07-ны өдрүүдэд томилогдон ажиллаж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан, тайланг Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.<br>2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/116 дугаар тушаалаар Бүгд Найрамдах Эстони Улсын Таллин хотноо 2024 оны 11 дүгээр сарын 23-наас 28-ны өдрүүдэд томилогдон ажиллаж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан, тайланг Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.<br>3. Мөн эрхэлсэн ажлын хүрээнд олон улсын байгууллагатай хамтран дараах сургалт, хурал, семинарыг Монгол Улсад зохион байгуулсан. Үүнд:<br>3.1. 2024 оны 4 дүгээр сарын 08, 09-ний өдрүүдэд эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн хүрээнд Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүүхдийн Сан, Азийн цахим эрүүл мэндийн холбоо (AeHIN)-той хамтран "Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд" үндэсний зөвлөлдөх уулзалтыг 150 байгууллагын 380 ажилтны дунд хариуцан зохион байгуулж, цахим шилжилтийн үйл ажиллагаа, "Цахим-Эрүүл мэнд" цогц арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, холбогдох журмыг танилцуулсан. Тус уулзалтад Энэтхэг, Африк, Америк, Нигери улсын төлөөлөл | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оролцож туршлага хуваалцсан. /digitalhealth.gov.mn/<br>3.2. 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хиймэл оюуны нэвтрүүлэлтэд салбар хоорондын уялдааг хангах зорилгоор АНУ-ын Карнеги Меллон Их сургуулийн зөвлөх багш Диксон Памела Грахамтай хамтран яамдын мэдээллийн технологийн мэргэжилтнүүд, И-Монгол академи УТҮГ, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон Мэдээллийн технологийн үндэсний паркийн инкубаторын компаниудын төлөөлөл буюу нийт 60 албан хаагчдад "Хиймэл оюун ухааны хэрэглээ, хэрэгжилт, цаашдын чиг хандлага" сэдвээр семинар /workshop/ зохион байгуулсан. | | |
| 2. | **Арга хэмжээ 2.** Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох | Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцсон тоо | 2 | 4 | Дотоодод зохион байгуулагдсан дараах 9 сургалт, хурал, семинарт оролцсон. Үүнд:<br>- 2024.02.29-ний өдөр "Боловсролын салбарын их өгөгдөл" уулзалт;<br>- 2024.05.01-ний өдөр "И-Бизнес системийн дахин инженерчлэл"-ийн уулзалт;<br>- 2024.05.03-ны өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан "Цахимд хэвшье" /Digital First – D1/ арга хэмжээ;<br>- 2024.05.16-ны өдөр "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед авч хэрэгжүүлэх эрсдэлийн харилцаа холбооны төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг танилцуулах, санал солилцох уулзалт;<br>- 2024.05.21-ний өдөр "AI EdTech Mongolia 2024" арга хэмжээ;<br>- 2024.05.14-ний өдөр "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль"-ийн төслийн хэлэлцүүлэг;<br>- 2024.05.14-ний өдөр "Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг | 2024.01.01-2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх" цахим сургалт;<br>- 2024.06.19, 20, 21-ний өдөр "JICA" олон улсын байгууллагаас зохион байгуулсан "Кибер аюулгүй байдлын засаглал болон Аудит" сургалт;<br>- 2024.09.20-ны өдөр Боловсролын яам болон ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссоос хамтран зохион байгуулсан "Монгол Улсын боловсролын салбар дахь мэдээлэл харилцаа холбооны технологийн мастер төлөвлөгөө болон багш нарын цахим ур чадварыг нэмэгдүүлэх" арга хэмжээ; | | |

## Гурав. Нэмэлт ажил

| № | Үйл ажиллагаа | Биелэлт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|
| 1. | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Сайдын 2024 оны "Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж батлах тухай" А/56 дугаар тушаалын хэрэгжилтийн хангах | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Сайдын 2024 оны "Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж батлах тухай" А/56 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажиллаж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн байгууллагын дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт, нийцэл болон яамнаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан ба тайланг 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.<br>Хариуцсан чиглэлийн хүрээнд гарсан үр дүн:<br>▪ Байгууллагын дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт, нийцэл буюу нэгдүгээр хяналтын чиглэлийн хүрээнд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 321 дүгээр зүйлд заасан төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй агентлагийн дотоод зохион байгуулалтын үйл ажиллагааны мэдээллийг цуглуулж, хавсаргасан.<br>▪ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал буюу хоёрдугаар хяналтын чиглэлийн хүрээнд тус яамнаас 2023 онд 77, 2024 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 72 нийт 149 чиглэл, үүрэг даалгаврыг албан бичгээр агентлагт хүргүүлсний биелэлтийг хянан үзсэн. Ангилж авч үзвэл: | 100% |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2" colspan="2">Ангилал</th><th rowspan="2">Нийт</th><th colspan="2">Үүнээс:</th></tr>
<tr><th>2023 онд</th><th>2024 онд</th></tr>
<tr><td>1.</td><td rowspan="2">Хариутай бичиг</td><td>хугацаатай</td><td>57</td><td>29</td><td>28</td></tr>
<tr><td></td><td>хугацаагүй</td><td>6</td><td>-</td><td>6</td></tr>
<tr><td>2.</td><td colspan="2">Шууд хэрэгжүүлэх бичиг</td><td>73</td><td>38</td><td>35</td></tr>
<tr><td>3.</td><td colspan="2">Бусад бичиг</td><td>13</td><td>10</td><td>3</td></tr>
<tr><td colspan="3">Бүгд</td><td>149 (95.3%)</td><td>77 (98.6%)</td><td>72 (92%)</td></tr>
</table>
Дээрх хүснэгтээс харахад нийт 149 бичгийн 49% нь шууд хэрэгжүүлэх, 42% нь эргэн хариу өгөх, 9% нь бусад төрлийн бичиг байсан. Эргэн хариу өгөх бичгээс тодорхой хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн 40% нь хугацаа хоцорсон. Мөн нийт 149 албан бичгээс бүрэн хэрэгжүүлсэн 122, хэрэгжих шатанд байгаа 11, хэрэгжилт хангалтгүй 4, хэрэгжилтийг тооцоогүй 14 тус тус байсан бас дундаж үнэлгээ 95.3%-тай байна.
</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>2.</td>
<td>Авлигатай тэмцэх “5Ш” ажиллагааны хүрээнд “Шил” ажиллагааны хэрэгжилтийг хангах</td>
<td>
- Шил ажиллагааны хүрээнд 2023.03.27-нд “shilen.gov.mn” 1.0, 2024.03.25-нд 2.0 хувилбарыг ашиглалтад оруулж, үндэсний хэмжээнд “Шилэн индекс”-ийг зарлан, 14 удаагийн хэвлэлийн бага хурлаар иргэдийг мэдээллээр ханган ажилласан ба 2024.12.09-ны өдрийн байдлаар 39 төрлийн 970,355 мэдээллийг байршуулж, 15,758,833 удаагийн хандалтыг авсан.<br>
- Шил ажиллагааны хэрэгжилтийг 2024.04.17-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг хангасан.<br>
- Систем хөгжүүлэлтийн баталгаат хугацаанд багтаж ажлын даалгаварт туссан дутуу хөгжүүлэлтийн ажлыг хийлгэх талаар “Аствишн” ХХК-тай холбогдож, удаа дараалан шаардлага тавьж ажиллаж байна.<br>
- “Мэдээллийн түгээмэл хүртээмжийн олон улсын өдөр”-ыг тохиолдуулан Глоб интернэшнл төв ТББ-аас 2024.09.27-ны өдөр зохион байгуулсан "Шилэн мэдээллийн сан-мэдээллийн ил тод байдал" хэлэлцүүлэгт оролцож, сэтгүүлчид болон төрийн байгууллагуудын асуултад хариулт өгсөн.<br>
- Авлигатай тэмцэх газраас 2024.09.27-ны өдөр зохион байгуулсан “Олон нийтийн хяналт хэрэгжүүлэхэд төрийн байгууллагаас дэмжлэг үзүүлэх нь” төрийн албан хаагч нарыг чадавхжуулах сургалтад аймаг, нийслэлийн 42 албан хаагчдад сургалт хийсэн.<br>
- Системд байршуулсан 2000 оноос хойших газрын дэлгэрэнгүй мэдээллийг 2024.03.04-ний өдөр УИХ-ын Хянан шалгах түр хорооны ажлын хэсэгт цахим хэлбэрээр, хэрэгжилтийг УИХ-д танилцуулахаар 2024.04.22-ны өдрийн 01/858 болон 2024.11.11-ний өдрийн 01/827 тоот бичгээр ЕСАА, ЗГХЭГ-т тус тус хүргүүлсэн.<br>
- Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах, шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар 2024 оны 01/924, 01/983, 01/1142, 01/1147 тоот тус тус бичгийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан УИХ-ны гишүүний асуулгын хариуг бэлтгэж, 2024.08.20-ны өдрийн 01/161 тоот бичгээр хүргүүлсэн.
</td>
<td>100%</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | - "Шил ажиллагаа"-ны хэрэгжилтийг хангах Штабын бүрэлдэхүүн, удирдамжийг боловсруулж, Сайдын 2024.11.15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. | |
| 3. | Улсын онцгой комиссын даргын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 7 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах | - Улсын онцгой комиссын 2024 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 5 дугаар хуралдааны тэмдэглэл болон 2024 оны "Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 3 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд Улсын онцгой комиссын даргын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 7 дугаар тушаалаар байгуулагдсан шуурхай бүлгийн гишүүнээр томилогдож ажилласан.<br>- Улсын онцгой комиссын салбар дундын мэдээллийн нэгдсэн систем бий болгох, бэлэн байдлыг хангах хүрээнд нийт 8 удаагийн уулзалтыг ОБЕГ, ЭМЯ, ГЕГ, ЗТЯ, АТҮТ, ЭМХТ, ЭМДЕГ, И-Монгол академи УТҮГ-тай хийх үйл ажиллагааг шуурхай бүлэгтэй хамтран зохион байгуулж, улмаар мэдээллийн сан, системийн хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулан, гүйцэтгэсэн ажлын илтгэх хуудасны хамт 2024 оны 10 дүгээр сарын 17-ны өдрийн 01/587 тоот албан бичгээр Шадар сайдад хүргүүлсэн.<br>- Түүнчлэн тус шуурхай бүлгийн үйл ажиллагаанд Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /erp.e-mongolia.mn/-ийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, 2024 оны 09 дүгээр сарын 12-нд холбогдох сургалтыг И Монгол Академи УТҮГ-тай хамтран хийсэн. | 100% |
| 4. | Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжилтийг хангах *ЦХИХХС-ын 2024 оны А/42 дугаар тушаал/* | - Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/42 дугаар тушаалаар байгуулагдсан иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаатай уялдуулж, санал хүсэлт хүлээн авах дуудлагыг нэгтгэх, нэгдсэн бүртгэл бий болгох, системүүдийг интеграци хийх боломжийг судалж танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн нарийн бичгээр томилогдож ажилласан.<br>- Ажлын хэсгийн хурлыг 2024 оны 11 дүгээр сарын 11, 12-ны өдөр зохион байгуулж, хамтран ажиллах тухай 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 03/842 тоот албан бичгийг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.<br>- Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төвд 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд ажиллах бэлтгэл ажлыг хангаж ажилласан.<br>- Түүнчлэн ажлын хэсгийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх танилцуулга, тэмдэглэлийн төслийг боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/984 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улмаар 2024 оны 11 дүгээр сарын 27-ны | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулагдаж, 41 дүгээр хуралдааны тэмдэглэл батлагдсан. | |
| 5. | “Дижитал-Аймаг, Дижитал-Хот” зөвлөмж боловсруулах | - Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны “Цахим аймаг бодлогын зөвлөмж батлах тухай” А/53 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд “Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн аж, ахуй нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх” төслийн Дархан-Уул, Өвөрхангай аймагт хэрэгжүүлж буй гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлантай танилцаж, гүйцэтгэлийг үнэлэн, 2024 оны 8 дугаар сарын 08, 09-ны өдрүүдэд нийт 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж шаардлагатай зөвлөмжийг өгч ажилласан.<br>- ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/81 тоот тушаалын дагуу Өвөрхангай аймаг дахь “Цахим аймаг” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг газар дээр нь шалгах, зөвлөмж өгөх зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 23, 24, 25-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт ажиллан, холбогдох зөвлөмжийг аймгийн Засаг даргын газар болон гүйцэтгэгч байгууллагад өгч, үр дүнгийн тайланг 2024 оны 10 дугаар сарын 28-нд Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.<br>- 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Дархан-Уул, Өвөрхангай аймагт цахим шилжилтийг жишиг хэлбэрээр нэвтрүүлсэн үр дүн, олон улсын чиг хандлага, стандарт, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2025 оноос мөрдөгдөж эхлэх Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулиар төлөвлөгдөж буй засаг захиргааны нэгжийн өөрчлөлттэй уялдуулан “Дижитал-Аймаг, Дижитал-Хот” зөвлөмжийг боловсруулж, 2025 оны төсөвтөө суулган хэрэгжүүлэх талаар 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/1116 тоот албан бичгийг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлсэн. | 100% |
| 6. | Google компани өөрсдийн платформ дээр бүртгэлтэй системүүдийг шинэчилсэн холбогдуулан “DUNS” тусгай дугаарлалтын асуудлыг шийдвэрлэх | - Google компани өөрсдийн платформ дээрх аппликэйшн, системүүдийн бүртгэлийг шинэчилж, “DUNS” дугаарлалт хийж байгаатай холбогдуулан Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагуудын системүүд устах эрсдэлд орсон.<br>- Үүнтэй холбогдуулан Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагуудад “DUNS” дугаар олгуулах болон улсын хэмжээнд “DUNS” дугаарыг нээлгэх боломжийг бүрдүүлэх хүрээнд захидлыг 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдөр “Dun & Bradstreet” байгууллагад олон улсын платформоор дамжуулан хүргүүлсэн.<br>- Мөн тус дугаарыг нээлгэж чадахгүй байгаа болон “Google play Store” дээрх аппликэйшн нь устгагдах эрсдэлд орсон 298 аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй судалгааг гаргаж, 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн MDDIC/01/81 албан бичгээр Google компанийн Монгол талын төлөөлөгч нарт болон Google Android team, Government affairs and public policy (GAPP) багт хүргүүлэн, явцын мэдээллийг бүртгэгдсэн цахим шуудангаар судалгаанд хамрагдсан байгууллагуудад тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. | 100% |
| 7. | “Монгол Улсын Засгийн газар – НҮБ- | - “Монгол Улсын Засгийн газар – НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2023-2027 оны хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024-2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө”-ны төслийг | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | ын Хүүхдийн Сангийн 2023-2027 оны хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024-2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах | боловсруулан, гарын үсэг зурах үйл ажиллагааг 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр болон нэмэлт өөрчлөлт оруулах ажлын урьдчилсан бэлтгэл ажлыг хангаж, ЦХИХХСайд болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгч нар хамтран ажиллах төлөвлөгөөнд гарын үсэг зурах арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулсан. Мөн өдөр ЦХИХХСайд шилжилтийн чиглэлээр амжилттай хамтран ажиллаж байгааг онцлон, Хүүхдийн Санд цахим талархал гардууллаа.<br>- Тус төлөвлөгөөнд туссан эрүүл мэндийн салбарын цахим шилжилттэй холбоотой зорилтот арга хэмжээний хэрэгжилт бүрэн хэрэгжсэн. | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ | Г.ЭНХТУЛГА /........................../ | 2024 .... 12 .... 10 |
| ( Албан тушаал ) | ( Нэр, гарын үсэг ) | ( Огноо ) |

----оOо----